


ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт






ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2022 онд: **6%**,
Инфляци: 2022 онд: **8.2%**,
Урсгал тэнцэл: 2022 онд: **-10.2%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2021 оны тайланд прогноз хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>


ДНБ-ий өсөлт: 2022 онд: **7.5%**
Инфляци: 2021 онд: **7.3%**,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2022 онд: **-8.5%**- Олон улсын валютын сан (ОУВС)-ийн тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3qx1ORq>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 3-р сарын байдлаар 257.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.


Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 102.2 хувиар өссөн бол, зарлага 40 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 257.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 167.6 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

**Ам.долларын ханш өмнөх сараас 44.6 төгрөгөөр өсөв.**


Гуравдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 52.19 төгрөгөөр нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 44.6 төгрөгөөр нэмэгдэж 2901.83 төгрөг болов. 3-р сард гадаад валютын нөөц 3.3 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас -9.94 оны эхнээс 26.81 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 30 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

**Инфляцын түвшин 14.2%**

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2022 оны 3-р сарын байдлаар өмнөх сараас 0.8 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 14.4 хувиар, оны эхнээс 4 хувь өсөв. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 14.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 18 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 7.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 11.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 14.7 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 14.2 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 23.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**Гадаад худалдааны тэнцэл 251.4 сая.ам долларын ашигтай гарав.**

2022 оны гуравдугаар сард нийт барааны эргэлт 3632.7 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 3 хувиар өссөн бол экспорт өмнөх сараас 2.9 хувь буурч, импорт өмнөх оны мөн үеэс 10 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 251.4 сая ам.долларын ашигтай гарав.



3-Р САРЫН ОНЦЛОХ: ХАДГАЛАМЖ

Эх сурвалж: www.1212.mn

Нийт хадгаламж 2022 оны 3-р сард 17.9 их наяд төгрөг болж өмнөх сараас 486.4 тэрбум төгрөг буюу 2.6 хувиар буурсан бол өнгөрсөн оны мөн үеэс 3 хувиар буюу 374.6 тэрбум төгрөгөөр буурав. Тус сард төгрөгийн хадгаламж 13701.7 тэрбум төгрөг буюу өмнөх сараас 4.2 хувиар, валютын хадгаламж 4280.6 тэрбум төгрөг болж өмнөх сараас 2.7 хувиар нэмэгдэв. Үүнээс төгрөгийн хадгаламж 76 хувь, валютын хадгаламж 24 хувийг эзэлж байна. Харин өнгөрсөн оны мөн үеэс төгрөгийн хадгаламж 3.3 хувиар, валютын хадгаламж 2.2 хувиар буурчээ.

САРЫН ОНЦЛОХ

БАНКНЫ САЛБАРЫН АКТИВ 2.3 ХУВИАР НЭМЭГДЭЖ, ДНБ-ИЙ ХЭМЖЭЭНД ОЙРТОВ.

- Банкны салбарын үзүүлэлт 2021 онд харьцангуй тогтвортой, өсөлттэй байж, салбарын нийт актив 2.3 хувиар нэмэгдэж, ДНБ-ий хэмжээнд ойртжээ. IPO хийхээр төлөвлөж буй системийн 5 том банк өнгөрсөн онд санхүүгийн үзүүлэлт, чанар нь сайжирч, зээл, эх үүсвэр болон өөрийнх нь хөрөнгө өсөлттэй гарсныг Монголын банкны холбооноос мэдэгдэв. Өнгөрсөн онд “10 их наяд төгрөгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд репо санхүүжилт, ажлын байрыг дэмжих 3 хувийн хөнгөлөлттэй зээл, ипотекийн зээл олголттой холбоотой зээл 21 хувиар нэмэгджээ.

ТӨВ БАНК МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХҮҮГ 2.5 НЭГЖ ХУВИАР НЭМЖ 9 ХУВЬ БОЛГОЛОО.

- Төв банк мөнгөний бодлогын хорооны ээлжит хурлаар мөнгөний бодлогын хүүг 2.5 нэгж хувиар нэмж 9 хувь болголоо. Хилийн хязгаартай холбоотой нүүрсний экспортын хэмжээ хүлээлтэд хүрэхгүй, уул уурхайн салбарын өсөлт, эдийн засгийн өсөлтийг багасгана. Тээвэр худалдаа, эдийн засгийн тодорхойгүй байдал нийлүүлэлтийг хязгаарлаж байна. Хилийн хязгаарлалт сулрахгүй бол үнийн өсөлтийн төсөөллийг бууруулах нөлөөг хязгаарлаж байна. Цар тахлын үед өнгөрсөн 2 жилд төв банкны бодлого амжилттай хэрэгжүүлснээр 2021 оны хөдөлмөрийн зах зээлийг сэргээсэн. Харамсалтай нь гадаад орчны таагүй нөхцөл нь гадаад худалдааны нөхцөлийг муутгаж, нийлүүлэлтийн сүлжээг доголдуулсан зэргээс мөнгөний бодлогыг чангаруулах шаардлага бий болсон.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 3-р сар 2022 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 3-р сар 2022 он, Монголбанк
- www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn